

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН  
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ  
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН  
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2023 оны 01 дүгээр  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

“Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагууд /Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба/-д **2022 оны жилийн эцсийн байдлаар** иргэдээс төрийн байгууллага болон албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээ, тайланг нэгтгэн гаргалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 34 дүгээр хуралдаан, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд Засгийн газрын гишүүдэд өгсөн үүрэг, даалгаврын дагуу иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шат дамжлага, хүндрэл бэрхшээл багатайгаар нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэн ажиллаж байна.

Түүнчлэн Эдийн засаг, хөгжлийн яам болон харьяа байгууллагуудад нийт бичиг хэрэг, цахим шуудангаар 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 163 өргөдөл, гомдол ирснээс 158 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 5 өргөдөл, гомдол хуулийн хугацаанд судлагдаж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар 30 /гуч/ хоногийн хугацааг хэтрүүлж 22 өргөдлийг шийдвэрлэжээ.

Хугацаа хэтрүүлсэн тайлбар: Эдийн засаг, хөгжлийн яам нь шинээр байгуулагдсантай холбоотойгоор хүний нөөц дутуу байгаагаас шалтгаалан ажилд орох өргөдлийн хувьд тухайн иргэнтэй ярилцлага хийх, бусад байгууллагаас тодорхойлолт (нөөцөд байгаа г.м) гаргуулах, Авлигатай тэмцэх газарт ХАСХОМ хянуулах, харин ажлаас чөлөөлөгдөх өргөдлийн хувьд өргөдөл гаргасан албан хаагчийн ажил үүргийг хэвийн явуулах боломжийг бүрдүүлж, оронд нь ажиллах иргэнийг сонгох зэргээр хугацаа шаардагддаг тул хуульд заасан хугацаа хэтэрсэн тохиолдол гарсан болно.

**Нэг. Эдийн засаг, хөгжлийн яаманд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээлэл**

Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 109 өргөдөл, гомдол бичиг хэргээр дамжин ирснээс 1 дүгээр улиралд 14 өргөдөл, гомдол, 2 дугаар улиралд 38 өргөдөл, гомдол, 3 дугаар улиралд 36 өргөдөл, 4 дүгээр улиралд 21 гомдол тус тус бүртгэгдсэн байна.

Тус яам нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Засгийн газрын бүтцийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шинээр байгуулагдаж, Засгийн газрын 2022 оны 14 дүгээр тогтоолоор мөн онд үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор хүний нөөцийг бүрдүүлэх нь нэн тэргүүний ажил байсан тул “ажилд орох болон чөлөөлөгдөх”-тэй холбоотой өргөдлүүд нийт өргөдөл гомдлын 54.5 хувийг эзэлж байна.

Харин Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой гомдлууд нь Гадаадын хөрөнгө оруулагчдын зүгээс “нэг цэгийн үйлчилгээний газрын үйл

ажиллагаанд сэтгэл хангалуун бус” болон тус үйлчилгээний төвд ажиллаж байгаа төрийн бусад байгууллагын албан хаагчид ажилдаа цагтаа ирэхгүй, утсаа авахгүй байгаа талаар гомдол гаргасан байна. Энэ талаар яамны зүгээс хөрөнгө оруулагч нарт нэг цэгийн үйлчилгээ үзүүлж байгаа утсыг ажлын цагаар тогтмол нээлттэй байлгах, бусад байгууллагуудын албан хаагчдыг ажлын цагаар ажлын байраа орхихгүй байхыг холбогдох байгууллагад нь шаардлага тавих зэргээр нэгдсэн арга хэмжээ авч ажилласан.

Мөн Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын II байрны чанар, стандартын шаардлага хангахгүй байдал, албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж дутмаг байгаа талаар албан хаагчдаас гомдол ирүүлсэн. Тус гомдлын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагаа явуулах байрыг өөр байр луу шилжүүлэх талаар судалж, тус судалгааг үндэслэн холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн улмаар шийдвэрлүүлж ажиллаж байна.

Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд шийдвэрлэж байгаа бөгөөд цаашид илүү түргэн шуурхай, иргэдэд хүндрэл чирэгдэлгүй ажиллаж, үйл ажиллагаагаа улам сайжруулахыг зорьж байна.

**Хоёр. Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээлэл**

Тус захирагчийн ажлын албанд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 26 өргөдөл, гомдол бүртгэгдсэн бөгөөд бүгд хүний нөөцийн асуудалд хамаарч байна. Эдгээр өргөдөл, гомдлын шийдвэрлэлт Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн байна.

**Гурав. Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээлэл**

Тус захирагчийн ажлын албанд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 28 өргөдөл, гомдол бүртгэгдсэн ба үүнээс 22 өргөдөл хүний нөөцийн асуудлаар, Алтанбулаг чөлөөт бүсийн хилийн боомтын үйл ажиллагааны талаар гаргасан 6 өргөдөл гомдол хамаарч байна. Эдгээр өргөдөл, гомдлын шийдвэрлэлт Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн байна.

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ**

Хавсралт-1

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,  
ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

/2022 оны жилийн эцсийн тайлан/

№	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт хувиар
			Нийт шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Үүнээс Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	Эдийн засаг, хөгжлийн яам	109	100	4	20	5	95.4%
2	Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба	26	26	-	-	-	100%
3	Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба	28	28	-	2	-	100%
	<b>Дүн</b>	<b>163</b>	<b>154</b>	<b>4</b>	<b>22</b>	<b>5</b>	<b>96.9%</b>

-----000-----

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,  
ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВСАН БАЙДАЛ

/2022 оны жилийн эцсийн тайлан/

№	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Үүнээс:				Бусад
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн хандсан	
1	Эдийн засаг, хөгжлийн яам	109	109	-	-	-	-
2	Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба	26	18	-	-	8	-
3	Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба	28	27	1	-	-	-
	<b>Дүн</b>	<b>163</b>	<b>163</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>8</b>	<b>-</b>

-----000-----

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД ХАНДАЖ  
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН АГУУЛГА**

/2022 оны жилийн эцсийн тайлан/

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудлын нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь			
		<i>Нийт өргөдлөөс:</i>		<i>тоо</i>	<i>Эзлэх хувь</i>
1	Эдийн засаг хөгжлийн яам	1	Хүсэлт	149	91.4%
		2	Гомдол	11	6.74%
		3	Санал	3	1.84%
		<b>Өргөдөл, гомдлын агуулга</b>			
		1	Ажилд орохыг хүссэн	46	28.2%
		2	Ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн	43	26.3%
		3	Хүүхэд асрах чөлөө болон бусад чөлөө хүссэн	34	20.85%
		4	Төрийн байгууллагын үйлчилгээний чаңар стандартын талаар	10	6.13%
		5	Тэтгэвэр тогтоолгох тухай	3	1.84%
		6	Бусад	27	16.56%
		<b>Дүн</b>		<b>163</b>	

----oooOooo----

2022 оны жилийн эцсийн иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдолд хамгийн олон хандалттай асуудал

№	Яамдын нэр	Нийт өргөдөл гомдол	Хөдөлмөр эрхлэлтэй холбоотой	Гэр орон сууц хүссэн	Санхүүгийн дамжлаг хүссэн	Нийгмийн халамжтай холбоотой	Нийгмийн даатгалтай холбоотой	Газрын харилцаатай холбоотой	Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой	Улсын бүртгэлтэй холбоотой	Салбарын үйл ажиллагаатай холбоотой	Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой
1.	Эдийн засаг, хөгжлийн яам	163	135	-	-	-	-	-	3	-	13	-